



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.13 № 151

танай _____-ны № _____-т

“АРХАНГАЙН УС СУВАГ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ Б.ЭНХСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангайн ус суваг” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд байгууллагын захиралд 2,219.4 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон;
2. Байгууллагын хөрөнгөөр биеийн тамир спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад оролцож дүрэмт хувцас худалдан авсан, ойн арга хэмжээнд хандив өгсөн, хүлээн авалт зохион байгуулсан зэрэгт нийт 15,393.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Дээрх 17,612.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.1.3, 4.1.6, 4.1.9, 4.2.1, 4.2.6, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15,006,122.33	2,256,741.22
1.1.02	Дансны авлага	24,341,096.97	16,336,711.43
1.1.04	Бусад авлага	47,777,409.60	48,255,724.10
1.1.06	Бараа материал	161,578,000.59	131,494,756.11
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	248,702,629.49	198,343,932.86
1.2.01	Үндсэн хөрөнгө	16,936,622,455.46	16,673,980,193.93
1.2.02	Биет бус хөрөнгө	3,399,510,000.00	3,396,710,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,336,132,455.46	20,070,690,193.93
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,584,835,084.95	20,269,034,126.79
2.1.1.01	Дансны өглөг	171,022,952.62	151,555,300.00
2.1.1.03	Татварын өр	63,809,599.63	88,652,167.36
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	1,937,786.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	234,832,552.25	241,858,890.22
2.1.2.01	Урт хугацаат зээл	11,211,764,698.88	12,142,538,997.53
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,211,764,698.88	12,142,538,997.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,446,597,251.13	12,384,397,887.75
2.3.01	Өмч: - төрийн	351,271,342.52	351,271,342.52
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	206,573,729.30	206,573,729.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	11,351,279,988.98	11,567,683,659.38
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,770,887,226.98)	(4,240,892,492.16)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(251,858,056.66)	(552,031,147.72)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(2,519,029,170.32)	(3,688,861,344.44)
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,138,237,833.82	7,884,636,239.04
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,584,835,084.95	20,269,034,126.79

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,700,517,041.55	1,808,440,743.54
02	Борлуулалтын өртөг	1,777,343,234.41	2,404,382,972.16
03	Нийт ашиг(алдагдал)	(76,826,192.86)	(595,942,228.62)
05	Хүүний орлого	20,757.76	0.00
08	Бусад орлого	17,462,801.82	280,834,644.70
08.1	Орлогын дүн	17,483,559.58	280,834,644.70
10	Ерөнхий ба удирдлагын зардал	134,611,887.14	234,904,472.89
12	Бусад зардал	8,145,454.54	2,019,090.91
12.1	Зардлын дүн	142,757,341.68	236,923,563.80
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(49,607,785.93)	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	(148,220.00)	0.00
17.1	Олз, гарзын дүн	(49,756,005.93)	0.00

“Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(251,855,980.89)	(552,031,147.72)
19	Орлогын татварын зардал	2,075.77	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(251,858,056.66)	(552,031,147.72)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(251,858,056.66)	(552,031,147.72)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,921,099,521.50	2,326,586,422.79
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,910,099,521.50	2,117,475,633.79
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	11,000,000.00	187,300,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	21,810,789.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,993,487,791.21	2,253,894,803.90
1.2.1	Ажиллагчдад төлсөн	820,328,188.62	955,864,858.54
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	226,290,282.21	276,940,313.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	190,808,593.30	193,882,454.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	366,624,998.06	441,078,532.30
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	134,800,694.00	140,867,890.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	215,528,351.76	190,496,951.61
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,878,605.11	2,048,511.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	37,228,078.15	52,715,293.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(72,388,269.71)	72,691,618.89
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,757.76	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,757.76	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,660,000.00	85,441,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,660,000.00	85,441,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,639,242.24)	(85,441,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(84,027,511.95)	(12,749,381.11)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,033,634.28	15,006,122.33
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,006,122.33	2,256,741.22

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,572,348,601.00	(984,214,617.68)	3,145,979,055.14
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн	0.00	0.00	0.00	(1,534,814,552.64)	(1,534,814,552.64)

“Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	нөлөө, алдааны залруулга					
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(251,858,056.66)	(251,858,056.66)
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	7,778,931,387.98	0.00	7,778,931,387.98
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	11,351,279,988.98	(2,770,887,226.98)	9,138,237,833.82
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(917,974,117.46)	(917,974,117.46)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(552,031,147.72)	(552,031,147.72)
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	216,403,670.40	0.00	216,403,670.40
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	11,567,683,659.38	(4,240,892,492.16)	7,884,636,239.04

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 17,839.3 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Эрдэнэбулган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 28 дугаар ухаалаг худгийн 17,839.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсныг аудитын явцад үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмж дансанд бүртгүүлж залрууллаа.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг”, 14.4.3-т “бүх өр төлбөрийг”, 14.4.5-т “бүх орлогыг” нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалтууд болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй нийт 17,612.4 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 2,219.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 15,393.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 17,612.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин **11,903.6** мянган төгрөгөөс их шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд байгууллагын захиралд тушаал шийдвэргүйгээр нууцын нэмэгдэл хөлсийг 10 хувиар нэмэгдүүлэн тооцож нийт 2,219.4 мянган төгрөгийн илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүй илүү олгосон нэмэгдэл хөлс 2,219.4 мянган төгрөгийг холбогдох ажилтнаас гаргуулан төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

3.2.1. Нийт аж ахуйн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын арга хэмжээний зардалд 7,055.0 мянган төгрөг, ойн баярын арга хэмжээний хүлээн авалтын зардалд 8,338.0 мянган төгрөг нийт 15,393.0 мянган төгрөгийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 -д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.6-д "Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийг бүртгээгүй орхигдуулсан	1	17,839.4	1	17,839.4			1	17,839.4				
Нийт дүн	1	17,839.4	1	17,839.4			1	17,839.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	2,219.4	1	2,219.4								
Арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	15,393.0			1	15,393.0						
	2	17,612.4	1	2,219.4	1	15,393.0						